



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ




JAPAN INTERNATIONAL  
COOPERATION AGENCY

МЭДЭЭЛЛИЙН ЭМХЭТГЭЛ №14 (2018 ОН 5-Р САР)

## Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)

### CRPD Сүүдэр тайлангийн тухай семинар (2018.05.16)

Японы Нийгмийн харилцааны их сургуулийн Сато Хисао профессор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан “Сүүдэр тайлангийн ач холбогдол, үр дүнтэй бичих аргачлал” сэдвээр семинар зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц нь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих үндсэн



Сато Хисао профессор

конвенц бөгөөд Монгол Улсын Засгийн Газар 2009 онд тус конвенцийг соёрхон баталж, хэрэгжилтийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Нөгөөтэйгүүр Засгийн газрын үйл ажиллагааны талаар ТББ-ууд Сүүдэр тайлан бичиж, санал бодлоо илэрхийлэх боломжтой. Энэ удаагийн семинарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн томоохон ТББ-уудын төлөөллүүд оролцож, Сүүдэр тайланг бичих аргачлал болон тайланг хүргүүлэх хуваарийн талаар Сато профессортой хамтдаа ярилцлаа. Мөн Сато багш Шинэ Зеландын жишээг танилцуулснаар үр дүнтэй бичих аргачлалын талаар тайлбарласан бөгөөд семинарт оролцогчид, DPUB төслийн хамт олны хувьд хэрэгтэй зөвлөгөө болж чадлаа. Удаагүй хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд Сүүдэр тайланг боловсруулах үйл ажиллагаагаа эхлүүлнэ. ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих үр дүнтэй тайлан болно гэдэгт итгэлтэй байна.

### ТББ-ын ажил



Төслийн ахлах зөвлөх Чибэ Хисао

Камбож улсад анх удаа ТББ-д ажиллахаар боллоо. Анх ТББ-ын талаар бодоход жирийн ард иргэд, ажлын талбар, ажилч хичээнгүй байдал, цалин бага гэсэн төсөөлөл толгойд орж ирж байсан бөгөөд ажиллаад үзэхэд бараг л миний бодсонтой ижил байсан.

Гэхдээ ажил үүргийн далайцын хувьд миний бодсоноос хамаагүй том байсан төдийгүй хүмүүс нь маш ажилсаг, хичээнгүй байсан юм. Харин Засгийн газрын баримталж буй зарчмыг эсэргүүцэх чиглэлээр ажиллаж байсантай нь би санал нэгдээгүй. Улс төрийн намуудын эсрэг гэх юм уу, ямар ч л байсан Засгийн газраас баримталж буй чиглэлийг эсэргүүцэх хандлага нь нэлээд хүчтэй байсан гэж бодож байна. Засгийн газарт хандаж ард иргэдийн хэрэгцээг сонсохыг шаардаж байсан боловч бодит байдал дээр хөгжил дэвшлийг эсэргүүцэх хүмүүс, дэмжих хүмүүс аль аль нь байсан. Тиймээс алиных нь хэрэгцээг чухалцан авч үзэх, зөв гэж бодох вэ гэдгийг эцсийн үр дүнд өөрийн үнэт зүйл дээр үндэслэн шийдэх ёстой юм байна гэж бодсон. Энэ утгаараа миний өөрийн үнэт зүйл болон ажиллаж байсан ТББ-ын үнэт зүйлүүд хоорондоо бага зэрэг зөрүүтэй байсан байж магадгүй. Азаар манай дарга үнэн бодитой тайланг хүсэж байсан учраас миний тайланг хүлээж авсан. Энэ нь надад бодит хэрэгцээ гэж юу вэ? мөн шаардлагатай хөгжил дэвшил гэж юу вэ? гэх мэтийн талаар нухацтай бодох туршлага болж өгсөн. Би одоо ч гэсэн аливаа хэрэгцээг тодорхойлоход бодит мэдээлэл, субъектив үнэт зүйл хоёр хоёулаа шаардлагатай гэж боддог.

Ингээд ТББ-д 1 жил ажилласныхаа дараа ямар ажил хийх талаар бодож эхэлсэн ба НҮБ-д ажиллах талаар дахин бодож эхэллээ. Хэрвээ НҮБ-д ажилд орвол Хөгжлийн бэрхшээлийн салбарт ажиллах юмсан гэж бодон, ТББ-ын ажлын гэрээ дуусах үед өмнөх дарга руу гаа холбоо барилаа. (Үргэлжлэл бий...)




Хигашида мэргэжилтэн

### Шинэ мэргэжилтэн ирлээ

Сайн байцгаана уу. 2018 оны 5-р сараас Исобэ мэргэжилтний оронд ажиллахаар болсон Хигашида Масатэру байна. Өнөөг хүртэл Япон (гамшигт өртсөн бүс нутаг г.м), Шри-Ланкын хөдөө орон нутгийн Хөгжлийн бэрхшээлийн салбар • Сэтгэцийн эрүүл мэнд, Халамжийн салбарт нийгмийн ажилтнаар ажиллаж байсан. Энэ удаа Монголд анх удаагаа ирж буй бөгөөд та бүхэнтэй хамтдаа үйл ажиллагаа явуулах болсондоо баяртай байна. Эхнэр маань 6-р сард ирэх бөгөөд Монголд ажиллаж, амьдрах цаг мөчүүдийг үр дүнтэй, хөгжилтэй өнгөрөөх болно.

**“Оюуны болон Сурах хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх орон нутгийн дэмжлэг ба үйл ажиллагаа” сэдэвт сургалтын тайлангийн хурал зохион байгуулагдлаа. (2018.05.08)**



*Сургалтын оролцогч Бадамцэрэн*

Монгол улсад Оюуны бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх туламж дэмжлэг хамгийн хоцрогдолтой байгаа юм. Өнөөдөр төслийн оффист Япон дахь сургалтын оролцогч Бадамцэрэнгийн тайлангийн хурал зохион байгуулагдсан ба Монгол болон Японы Оюуны бэрхшээлтэй иргэдийг дэмжих байгууллагуудын төлөөлөл оролцлоо. Түүний суралцаж, судлаад ирсэн халамжийн үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг нь нийгэм хамгаалал, халамжийн тогтолцоон дээр суурилсан зүйл юм. Тиймээс Монголд шууд нэвтрүүлэх нь хүндрэлтэй хэдий ч цэцэрлэг болон сургуулийн багш ажилчдад хүүхэд бүрийн ирээдүй, хөдөлмөр эрхлэлт зэрэг алсыг харсан дэмжлэг, тусламж үзүүлэх ёстойг түгээх хүсэлтэй байгаагаа илэрхийлж байлаа. Төслийн зүгээс ч гэсэн цаашдын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн, улсын цэцэрлэг, сургуулиудад тайлангаа тавих боломжийг бий болгох чиглэлээр хамтран ажиллах болно.



*Тайлангийн үеэр*

**“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо”-ны төлөөлөлтэй уулзалдлаа. (2018.05.15)**

4-р сарын 30-ны үдээс хойш “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо”-ны холбогдох төлөөлөлтэй уулзаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Одоогийн байдлаар манай төсөл Хүртээмж болон Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын чиглэлээр голлон үйл ажиллагаа явуулж байгаа учраас Эцэг, эхийн холбоотой хамтран хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаа хязгаарлагдмал байгаа юм. Тус уулзалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчлэхэд оюуны бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн тусламж, дэмжлэгтэй холбоотой агуулгыг тусган оруулах, хөдөлмөр эрхлэлттэй холбогдуулан оюуны бэрхшээлийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах, ажил олгогч, бизнесийн байгууллагуудад DET сургалт явуулах гэх мэт хамтран хэрэгжүүлэх боломжтой ямар ажил байгаа талаар ярилцлаа. Япон улсын жишээнээс харахад Нийгэм, халамжийн байгууллага болон Ашгийн төлөө бус байгууллагууд Засгийн




*Уулзалтын дараа*

газраасаа санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд төрөөс санхүүжилт авалгүйгээр үйл ажиллагаа явуулах нь маш хүндрэлтэй байдаг. Хөгжиж буй орнуудын хувьд нийгэм хамгааллын тогтолцоо нь хангалттай сайн бэхжээгүй учраас төрөөс ирэх санхүүжилт байдаггүй. Тиймээс ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулах нь хүндрэлтэй байдаг. Цаашид ХБИ-ийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд тухайн бүс нутгийн баялагийг ашиглах шаардлагатай. Энэ удаагийн уулзалтаар нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай гэдгийг улам илүү ойлголоо. Цаашид төслийн хамт олон улам илүү хичээн ажиллах болно.

**NTV-тэй хамтран ажиллахаар боллоо. (2018.05.16)**

“Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)” Монгол улсад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд NTV-тэй хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлийн нөлөөллийн үйл ажиллагааг явуулахаар боллоо. DPUB төслийн зүгээс өнөөг хүртэл Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-аар дамжуулж хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн бөгөөд цаашид нийгэмд илүү өргөн хүрээнд мэдээлэл түгээж, хандлага,



*Хамтран ажиллах гэрээ байгууллаа*

ойлголтыг нэмэгдүүлэхийг зорьж байна. Цаашид телевизээр төслийн үйл ажиллагаатай холбоотой олон мэдээлэл цацагдах бөгөөд та бүхнийг ч гэсэн биднийг дэмжин, хамтран ажиллахыг хүсэж байна. Хамтдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжин ажиллацгаая.

**ХБИ-ийн талаарх мэдээллийн ном ХНХЯ-ны цахим хуудсанд тавигдлаа. (2018.05.10)**

Доорх цахим хуудсаар нэвтэрч мэдээллийн ном(Монгол, Англи, Япон хэл)-той танилцна уу!  
[www.mlsp.gov.mn/nnews/298](http://www.mlsp.gov.mn/nnews/298)

**DPUB Холбоо барих хаяг**

**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ  
**Фэйсбүүк хуудас:** <https://www.facebook.com/jicadpub>  
**Цахим хуудас:** <https://www.jica.go.jp/project/mon-golia/015/index.html>  
**И-мэйл:** [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)

**ЛІСА DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж нэгдээрэй!!**